



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,  
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 171,500,000.00 (нэг зуун далан нэгэн сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Улсын хүүхэлдэйн театрын захирал З.Баянзул, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Ц.Ганчимэг нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уүрэг брлгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132001339  
12-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн  
дугаар тогтолцоны хавсралт

**ГААПИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, УЛДЭХ ӨРТӨГТГҮЙ АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАДАА  
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖУУЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Хуулийн этгээдийн нэр	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн отноо/Ашиглалтад орсон отноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ, хуриатлагдсан эпээдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа жилээр/	Шилжүүлэх хуулийн этгээдийн нэр
1	Гаалийн өрөнхий газар	Хьюндай соната-7, арлын дугаар КМНЕВ41АВЕА609888, улсын дугаар 05-74 ҮНҮ	2013/2014	1	ш	59,500,000.00	6,000,000.00	6,000,000.00	3	"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэгтийг дэмжих төв" УТГУГ
2	Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газар	Хьюндай Коунти, арлын дугаар КМЛНГ17ЛРЕС063068, улсын дугаар 41-61 ҮНИ	2014/2014	1	ш	112,000,000.00	6,000,000.00	6,000,000.00	3	Улсын хүүхэлдэйн театр
<b>Нийт дүн</b>							<b>171,500,000.00 (нэг зуун далан нэгэн сая таван зуун мянга)</b>	<b>12,000,000.00 (арван хоёр сая)</b>		